



ХЭНТИЙ АЙМАГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 47

Хэрлэн сум

Баянхутаг сумын Засаг даргын Тамгын газрын  
Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан  
мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо (65,0) авсан Болдын Бат-Эрдэнийг Баянхутаг сумын Засаг даргын Тамгын газрын Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Б.Бат-Эрдэнийг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Баянхутаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Золбоо)-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Баянхутаг сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА

